

Монгол хүн сансрын уудамд

Дэлхийд хамгийн түрүүнд ЗХУ анхны хиймэл дагуулаа 1957 онд сансар огторгуйд хөөргөж, улмаар анхны хүн суулгасан сансрын хөлгөө 1961 онд хөөргөсөн билээ. ЗХУ сансарт үнэхээр хүчирхэг байж, анхны болгоны, тодруулбал, анхны хиймэл дагуул, анхны сансрын хөлөг, анхны амьтан, анхны нисгэгч, анхны эмэгтэй нисгэгч, анхны задгай сансар, анхны станц, анхны хос нисгэгч, анхны гурван нисгэгч, анхны хос хөлөг, анхны гадаад нисгэгч, анхны жуулчин гээд олон зүйлийн анхдагч болж хүн төрөлхтөний түүхнээ тодоор бичигдсэн билээ.

Ийнхүү ЗХУ “Спутник-1” нэртэй анхны хиймэл дагуулыг 1957 оны 10 дугаар сарын 04-нд амжилттай хөөргөж, улмаар 1961 оны 04 дүгээр сарын 12-нд сансрын нисэгч Ю.А.Гагарин “Восток-1” хөлгөөр сансар огторгуйд 108 минут буюу 1 цаг 50 минут орчим нисэн дэлхийг бүтэн тойрсон нь дэлхий дахинаа сансар огторгуй, од эрхсийг судлах гарцыг нээжээ.

Энэ цагаас хойш дэлхийн улс орнууд сансар огторгуйг судлах, энэ талаарх олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл идэвхтэй өрнөсөн. Тухайлбал, 1967 оны “Сансрын огторгуй, түүнчлэн сар болон тэнгэрийн бусад эрхсийг шинжлэх, ашиглах талаар улс гүрний явуулах үйл ажиллагааны зарчмын тухай”, 1968 оны “Сансрын нисэгчдийг аврах, мөн нисэгчдийг эгүүлэн өгөх, сансрын огторгуйд хөөргөсөн биет юмыг эгүүлэн өгөх тухай хэлэлцээр”, 1972 оны “Сансрын биетээс хохирол учруулсны олон улсын хариуцлагын тухай конвенц”, 1975 оны “Сансрын огторгуйд хөөргөсөн биетүүдийг бүртгэх тухай конвенц”-ууд юм.

Манай улс 1921 оноос эхлэн Зөвлөлт засаг, социалист бүтээн байгуулалтыг тууштай дэмжсэний үр дүнд ах дүүгийн найрамдалт ЗХУ-ын тусламж дэмжлэгтэйгээр Азийн улс орнуудаас Вьетнам улсын дараа хоёрдугаарт “сансрын уудам”-д хөл тавьсан түүхтэй.

Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ой өнөөдөр тохиож байна.

Монгол Улсын иргэн, сансрын нисгэгч Ж.Гүррагчаа, ЗХУ-ын сансрын нисгэгч В.А.Жанибековын хамтаар 1981 оны гуравдугаар сарын 22-ны өдрийн 14:58 цагт хуучнаар ЗХУ-ын Байконур дахь сансрын талбайгаас “Союз-39” хөлгөөр хөөрсөн.

Тэд сансарт нийт найман өдрийн турш дэлхийг 124 удаа тойрч, гуравдугаар сарын 30-нд эх дэлхийдээ амжилттай газардсан байна.



ЗХУ, БНМАУ-ын сансрын хамтарсан нислэгийн "СОЮЗ-39" хөлөг сансарт цойлон нислээ. 1981.03.22, Гэрэл зургийг С.Батсүх

МУУТА. КГЗДАБА. К-41718



ЗХУ, БНМАУ-ын сансрын хамтарсан нислэгийн багийн гишүүд нислэгээ амжилттай хийгээд эх дэлхийдээ бууж ирсний дараа. 1981.04.01, Гэрэл зургийг С.Батсүх

МУУТА. КГЗДАБА. К-41833



ЗХУ, БНМАУ-ын сансрын хамтарсан нислэгийн "СОЮЗ-39" хөлгийн багийнхныг
Сүхбаатарын талбайд угтан авах хүндэтгэлийн жагсаал. Гэрэл зургийг С.Батсүх
МУУТА. КГЗДАБА. К-42228

МОНГОЛ УЛС

















